



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 15-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-13
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	14-38
<hr/>	
1.Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.10.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэл/	14-34
2.“Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /үргэлжлэл/	34-35
3.Баталсан хуулиудын эцсийн найруулгыг танилцуулах	35-38

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
11 дүгээр сарын 15-ны өдөр /Баасан гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 69 гишүүн хүрэлцэн ирж, 54.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 00 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Батцэцэг, Д.Ганмаа, Л.Мөнхбаясгалан, Т.Мөнхсайхан, О.Саранчулуун, А.Ундраа, С.Цэнгүүн, Л.Энх-Амгалан;

Чөлөөтэй: Л.Оюун-Эрдэнэ;

Эмнэлгийн чөлөөтэй: Б.Батбаатар, Х.Болормаа, Л.Гантөмөр, Ц.Даваасүрэн, Б.Жаргалан, Д.Үүрийнтуяа;

Тасалсан: Т.Аубакир, Д.Ганбат, Б.Дэлгэрсайхан, С.Лүндэг, Н.Номтойбаяр, Ж.Энхбаяр;

Хоцорсон: Н.Алтаншагай-10 минут, С.Амарсайхан-04 минут, Х.Баасанжаргал-03 минут, М.Бадамсүрэн-07 минут, Д.Батлут-03 минут, Ж.Батсуурь-08 минут, Ж.Бат-Эрдэнэ-20 минут, Э.Болормаа-16 минут, Х.Булгантуяа-06 минут, Ж.Галбадрах-01 минут, А.Ганбаатар-05 минут, Г.Ганбаатар-18 минут, П.Ганзориг-01 минут, Т.Доржханд-06 минут, Б.Жавхлан-09 минут, Х.Жангабыл-07 минут, П.Мөнхтулга-05 минут, Ц.Мөнхтуяа-01 минут, З.Мэндсайхан-35 минут, С.Одонтуяа-01 цаг 07 минут, Б.Пунсалмаа-38 минут, Д.Пүрэвдаваа-01 минут, Ц.Туваан-01 минут, Б.Тулга-23 минут, Х.Тэмүүжин-06 минут, Г.Тэмүүлэн-01 минут, Ч.Ундрал-01 минут, Н.Учрал-03 минут, Г.Уянгахишиг-01 минут, Б.Чойжилсүрэн-11 минут, Б.Энхбаяр-01 минут, Д.Энхтуяа-05 минут, Р.Эрдэнэбүрэн-48 минут.

Нэг.Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.10.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэл/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Д.Цолмон, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн дарга Н.Жамъянхүү, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хуулийн хэлтсийн дарга Т.Ганбаатар, мөн яамны Техник,

технологийн хэлтсийн дарга Г.Намчинсүрэн, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Усны газрын дарга З.Батбаяр, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Салбарын хяналтын газрын дарга Б.Мөнхтогтох, Цөмийн энергийн комиссын Цөмийн технологийн газрын дарга М.Чадраабал, мөн комиссын Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга Э.Нямдаваа, Санхүүгийн зохицуулах хорооны Хууль, эрх зүйн газрын дарга Ж.Мөнх-Оргил, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын мэргэжилтэн Б.Агиймаа, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, мөн компанийн Хууль, эрх зүйн газрын ахлах менежер Б.Гэрлээ, “Мон Атом” ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Далайжаргал, мөн компанийн Захиргааны удирдлагын албаны дарга Д.Сугарсүрэн, Геологи, уул уурхайн албаны ахлах инженер А.Алтанхундага, мэргэжлийн шинжээч Н.Тэгшбаяр, Г.Жамсрандорж, Л.Жаргалсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх П.Хулан, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа нар байлцав.

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо **дэмжсэн санал**

Д.Амарбаясгалан: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 8.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.1.4.энэ хуулийн 5.4, 5.5-д заасан төрийн эзэмшлийн хувь, хэмжээг өөрөөр тогтоох болон энэ хуулийн 5.5-д заасан хувилбараар орлуулах эсэх асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр, эсхүл өөрийн санаачилгаар шийдвэрлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 68

Татгалзсан: 23

Бүгд: 91

74.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут, Д.Энхтүвшин, Б.Бейсен, Д.Батбаяр, Г.Уянгахишиг, С.Эрдэнэболд нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 91 гишүүнээс 74 гишүүн дэмжиж, 81.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 9.1.9 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.1.9.энэ хуулийн 5.4, 5.5-д заасан төрийн эзэмшлийн хувь, хэмжээг өөрөөр тогтоох болон энэ хуулийн 5.5-д заасан хувилбараар орлуулах саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 30
Бүгд: 95
68.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, С.Зулпхар, Д.Энхтүвшин, Б.Жавхлан, Ж.Галбадрах, Р.Батболд, Д.Энхтуяа, С.Замира, Ж.Чинбүрэн нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 95 гишүүнээс 74 гишүүн дэмжиж, 77.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Ч.Анар, С.Ганбаатар, Г.Тэмүүлэн, Б.Батбаатар, О.Батнайрамдал, Н.Батсүмбэрэл, Ж.Баясгалан, Н.Номтойбаяр, Б.Уянга, Г.Уянгахишиг /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 20¹ дүгээр зүйлийн 20^{1.4} дэх хэсгийн “хувь” гэсний өмнө “үндсэн” гэж нэмж, мөн зүйлийн 20^{1.6}, 20^{1.7} дахь заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“20^{1.6}.Энэ хуулийн 20^{1.5}-д заасан ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг тухайн ордын онцлог, цацраг идэвхт ашигт малтмалын зах зээлийн үнийн түвшнийг харгалзан Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг үг хэлэв.

Зөвшөөрсөн: 81
Татгалзсан: 15
Бүгд: 96
84.4 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 20^{1.9} дэх хэсгийн “олборлосон” гэсний дараа “цацраг идэвхт” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 79

Татгалзсан: 17
 Бүгд: 96
 82.3 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалтын 28.2.12 дахь заалтын дугаарыг “28.2.11” гэж өөрчилж, 4 дүгээр зүйлийн “28 дугаар зүйлийн” гэсний дараа “28.2.11 дэх заалтын дугаарыг “28.2.12” гэж, мөн зүйлийн” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 79
 Татгалзсан: 18
 Бүгд: 97
 81.4 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалтын 34.3 дахь хэсгийн “олборлолт” гэсний дараа “баяжуулалт,” гэж, “аюулгүй” гэсний дараа “булшлах” гэж тус тус нэмж, мөн хэсгийн “гүйцэтгэх” гэснийг “гүйцэтгэгч” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 69
 Татгалзсан: 30
 Бүгд: 99
 69.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Д.Энхтүвшин, О.Номинчимэг нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 99 гишүүнээс 72 гишүүн дэмжиж, 72.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалтын 34.4.1 дэх заалтын “батлан мөрдөх” гэснийг “баталгаажуулан мөрдөх, шаардлагатай тохиолдолд гүйцэтгэлийг олон улсын хөндлөнгийн шинжээчээр хянуулах” гэж өөрчилж, 34.4.2 дахь заалтын “нэн” гэснийг, 34.8 дахь хэсгийн “15.2.1,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 77
 Татгалзсан: 22
 Бүгд: 99
 77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалтын 34.5 дахь хэсгийн “төрийн дансанд” гэснийг “Ирээдүйн өв сангийн Монголбанк дахь валютын тусгай дансанд” гэж өөрчлөх гэсэн саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Ч.Анар нар үг хэлж, уг саналаар санал хураалт явуулаагүй болно.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “5 дугаар зүйлийн 5.2, 5.3 дахь хэсэгт “Төрийн эзэмшлийн хувь хэмжээг цацраг идэвхт ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулж болно.” гэсэн өгүүлбэр,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 79
Татгалзсан: 20
Бүгд: 99
79.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай, Д.Энхтүвшин, С.Замира, Ц.Идэрбат, С.Эрдэнэболд, Д.Батбаяр нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 99 гишүүнээс 85 гишүүн дэмжиж, 85.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, П.Сайнзориг нарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 5.4 дэх хэсгийн 1 дүгээр зүйлд шилжүүлж, 5.5 болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2/5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэг:

“5.5.Энэ хуулийн 5.2, 5.3-т заасан төрийн эзэмшлийн хувь, хэмжээг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах, бүтээгдэхүүн хуваах, төрийн эзэмшлийн хувьцааны төрлийг өөрчлөх, эдгээрийг хослуулах зэрэг үр өгөөжийн дийлэнх нь Монгол Улсад ногдох хувилбарыг харгалзан Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал өөрөөр тогтоож болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 82
Татгалзсан: 17
Бүгд: 99
82.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Д.Батбаяр, Д.Энхтүвшин, У.Отгонбаяр, Ц.Идэрбат нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 99 гишүүнээс 87 гишүүн дэмжиж, 87.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтын 12.2 дахь хэсгийн “байцаагчийн” гэснийг “байцаагч (цаашид “улсын байцаагч” гэх)-ийн гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 80

Татгалзсан: 19
 Бүгд: 99
 80.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал

Д.Амарбаясгалан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 80
 Татгалзсан: 19
 Бүгд: 99
 80.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжээгүй санал

Д.Амарбаясгалан: 1.Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын 9.1.10 дахь заалтын “тогтоох” гэсний дараа “, цацраг идэвхт ашигт малтмал эрэх, хайх, ашиглах тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, Улсын Их Хурлын зөвшөөрснөөр эрэх, хайх, ашиглах тусгай зөвшөөрлийг олгох, бусдад шилжүүлэх” гэж нэмэх гэсэн Эдийн засгийн байнгын хороо дэмжээгүй, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн үг хэлэв.

Зөвшөөрсөн: 74
 Татгалзсан: 26
 Бүгд: 100
 74.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 20¹.3 дахь хэсгийн “борлуулалтын үнэлгээний 5 хувиар” гэснийг “борлуулалтын үнэлгээний 9 хувиар” гэж өөрчлөх гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжсэн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, П.Сайнзориг, С.Ганбаатар, Н.Батсүмбэрэл нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 82
 Татгалзсан: 20
 Бүгд: 102
 80.4 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Ч.Анарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалтын 34.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“34.5.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхай, үйлдвэрийн хаалт, нөхөн сэргээлт, хаалтын дараах засвар арчилгаанд зарцуулах мөнгөн хөрөнгийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нэр хүнд бүхий банк, санхүүгийн байгууллагын санхүүгийн хэрэгсэлд байршуулна.” гэсэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар, Б.Пүрэвдорж нар үг хэлж, Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар дээрх саналаа татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно.

4.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “30.1.1.тогтворжуулах татварын орчныг тогтоох;” гэсэн 3 дахь заалтыг хасах гэсэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр үг хэлж, дээрх саналаа татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно.

5.Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал, Б.Уянга нарын гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “20” гэж гэсний дараа “, мөн хэсгийн “байгуулж болох бөгөөд түүнд” гэснийг “гэрээний биелэлтийг 5 жил тутам дүгнэх, шаардлагатай тохиолдолд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд гэрээнд” гэж” гэж нэмэх гэсэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал үг хэлж, дээрх саналаа татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно.

6.Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “20” гэснийг “10-20” гэж өөрчлөх гэсэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 72
Татгалзсан: 30
Бүгд: 102
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

1.Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжээгүй санал

Д.Амарбаясгалан: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль

санаачлагчид нь буцаах гэсэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр үг хэлж, дээрх саналаа татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно.

2.Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжээгүй санал

Д.Амарбаясгалан: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр үг хэлж, дээрх саналаа татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно.

3.Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжсэн санал

Д.Амарбаясгалан: 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “Хуульд” гэсний өмнө “Цөмийн энергийн тухай” гэж нэмэх гэсэн Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Б.Энхбаяр, Х.Тэмүүжин, Д.Цогтбаатар, Б.Мөнхсоёл нар үг хэлэв.

Зөвшөөрсөн:	85
Татгалзсан:	19
Бүгд:	104

81.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 104 гишүүнээс 86 гишүүн дэмжиж, 82.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 11 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /үргэлжлэл/

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх нар байлцав.

Д.Амарбаясгалан: “Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	62
Татгалзсан:	42
Бүгд:	104

59.6 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Номин, С.Эрдэнэбат, Б.Хэрлэн, Х.Жангабыл, Б.Бат-Эрдэнэ, С.Замира, С.Амарсайхан, М.Ганхүлэг, М.Нарантуяа-Нара, Р.Батболд, П.Батчимэг, Д.Батбаяр, Ц.Мөнхбат, С.Эрдэнэболд нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 104 гишүүнээс 76 гишүүн дэмжиж, 73.1 хувийн саналаар тогтоол батлагдлаа. /11:10/

Уг асуудлыг 11 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. Баталсан хуулиудын эцсийн найруулгыг танилцуулах

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан дараах хуулиудын эцсийн найруулгыг танилцуулав. Үүнд:

1. “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /11:10/

2. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /11:11/

Дагалдан гарсан:

3.Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:11/

4.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:11/

5.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:12/

6.Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:12/

7.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:12/

8.“Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./11:12/

9.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгатай холбогдуулан *Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг санал хэлж, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж тайлбар хийв.* Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./11:15/

10.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчид”-д нэмэлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./11:15/

11.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:15/

Холбогдуулан боловсруулсан:

12.“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:16/

13.Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:16/

14.Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:16/

15.Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:16/

16.“Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:17/

17.“Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./11:17/

Уг асуудлыг 11 цаг 17 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцөөж, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 1 цаг 17 минут үргэлжилж, 126 гишүүнээс 105 гишүүн хүрэлцэн ирж, 83.3 хувийн ирцтэйгээр 11 цаг 17 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

**МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРАЛ**

2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр, Баасан гараг
Төрийн ордон “Их хуралдай”
танхим
10 цаг 00 минут

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өглөөний амгаланг айлтгая.

68 гишүүн ирж, ирц 54.8 хувь хүрсэн учраас өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдааныг эхлүүлье.

Өнөөдрийн хуралдаанаар дараах гурван асуудлыг хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Хоёрдугаарт, “Монгол Улсын Их Хурлын 2024-28 оны стратеги төлөвлөгөөг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Гуравдугаарт, Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсоно. Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч дууссан байгаа.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураана. Зарчмын зөрүүтэй 21 санал байгаа.

Зарчмын зөрүүтэй саналыг тайлбарлаж түүнийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж, мөн аль нэг нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй тус бүр 2 гишүүн, 2 хүртэл гишүүн үг хэлж болно гэсэн ийм хуулийн заалт байна. Дараалал.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41.5-д асуулт, хариулт дууссаны дараа Байнгын хорооноос санал хураалгахаар бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёолол тус бүрээр дараах журмаар санал хураалт явуулна гэж заасан байна.

Мөн хуулийн 41.5.1-д хуулийн төслийн талаар Байнгын хороо нам, эвслийн бүлэг, гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналыг тайлбарлаж, түүнийг дэмжсэн, эсрэг байр суурьтай бүлгийг төлөөлж, мөн аль нэг нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй тус бүр 2 хүртэл гишүүн 4 минутаас илүүгүй хугацаанд үг хэлсний дараа санал хураалтыг явуулна.

Мөн хуулийн 41.5.2-т хуралдаан даргалагч зарчмын зөрүүтэй санал тус бүрээр Байнгын хорооны саналаар санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэх, мөн хуулийн 41.6-д хуралдаан даргалагч санал хураалт явуулах цагийг урьдчилан товлон зарлана гэсэн.

Тэгээд өнөөдөр буюу Баасан гаргийн нэгдсэн хуралдаанаар санал хураалт явуулахыг өчигдөр зарласан байгаа.

Ингээд зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалтаа эхлүүлье.

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Нэг.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо дэмжсэн санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 8.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.1.4.энэ хуулийн 5.4, 5.5-д заасан төрийн эзэмшлийн хувь, хэмжээг өөрөөр тогтоох болон энэ хуулийн 5.5-д заасан хувилбараар орлуулах эсэх асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр, эсхүл өөрийн санаачилгаар шийдвэрлэх”. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Уянгахишиг.

Уянгахишиг гишүүн гаргасан санал өчигдөр асуулт ярьж байсан. Энэ дээр үг авахаар байгаа юу? Санал хураадгаараа хураагаад. Санал, намын бүлгийг төлөөлж дэмжээгүй байр суурь Ганбаатар гишүүн илэрхийлнэ тийм ээ? С.Ганбаатар гишүүн. Нэр ирсэн байгаа билүү?

С.Ганбаатар гишүүн үг хэлнэ.

С.Ганбаатар: Би аядуу зөөлөн Улсын Их Хурлын гишүүдийн хүндэтгэлтэйгээр хандаж ярина. Гэхдээ л айл гэрийн, айл гэрт хүүхдүүд нь өлсгөлөн, ажилгүй, орлогогүй байхад гаднынхан орж ирээд дээрэмдэж, тонуулдаж байхад аяндаа дуу маань өндөрсдөг юм. Зөвөөр ойлгоорой. Би аядуу зөөлөн ярина.

Та нар Цөмийн энергийн тухай хуулийг өөрчлөөд шар нунтаг гаргадаг орон болохоор хууль гаргаж байгаа шүү дээ. Цөмийн энергийн хямд эрчим хүч гэдэг бол бидний хувьд мөрөөдөл болсон, бүр ярих ч хэрэггүй болсон. Өнөөдөр Монгол орон стратегийн ашигт малтмал гэдгээсээ ураныг бид гаргаж байгаа, хууль баталж байгаа. 126 гишүүн мэдэхгүй ярьж байгаа бол, мэдэхгүй шийдвэр гаргаж байгаа бол та нарын буруу биш байж болно. Одоо би мэдээлэл өгөөд та нар мэддэг боллоо. Одоо ингээд буруу шийдвэр гаргах бидэнд эрх байхгүй.

Та нарт нэг сонин юм хэлье. Энэ танилцуулга дээр байгаа. Энэ 15 онд орж ирж байсан. Энэ бас 2 танилцуулга би хийе.

15 онд Ардчилсан нам эрх барьж байсан үед орж ирж байсан энэ цөмийн энергийн тухай ажлын албаны мэдээлэл дотор “АРЕВА” 34 хувийг чинь өгөөд, хувийг өгөөд дээр нь 9.5 хувийн роялти өгье гэдэг дээр хүлээн зөвшөөрөөд ороод ирчихсэн байгаа шүү. Энэ 15 оны 6 сарын 26-ны бичиг. Би судалгаатай ярина, үндэслэлтэй ярина. Өчигдөр Даваасүрэнг бүх хэвлэл мэдээллээр л яриад байна. Даваасүрэн гишүүнийг 9 хувийг ард түмнийхээ төлөө өгье гэсний төлөө яагаад борлуулж байгаа юм бэ? Энэ чинь “АРЕВА” өөрөө 9.5-ыг одоо байгаа 34 хувь дээр өгье гэж өөрсдөө санал оруулчихсан байгаа шүү дээ. Үгүй энэ чинь Францын парламент дээр бид суугаагүй шүү дээ.

Тэгэхлээр миний хэлэх гээд байгаа зүйл гэвэл Токаевын энд гаргасан, Казахстаны Ерөнхийлөгч Токаевын гаргасан 6 дугаар хуудсан дээр байгаа энэ танилцуулга, материалаа та нар уншаад үзээрэй. Ураны үнэ хамаагүй, үнэ хамаагүй. Ураны эрэлт, хэрэгцээ, хяналт чухал. Бүх урантай энэ цацраг идэвхт ашигт малтмалтай ордууд, улсууд ураныг төрийнхөө хяналтад, шууд хяналтад байлгадаг болохоос биш манайх шиг 34 хувиасаа татгалзаж гаднынханд өгдөггүй юм.

Тэгээд миний асуултад ерөөсөө өнөөдөр хүртэл хариулаагүй. Би ажлын хэсэгт нь орж ярилаа, хэлэлцэх эсэхэд нь орж асууж ярилаа, Аюулгүйн байнгын хороонд нь баахан ярилаа, өнөөдөр ингээд хурдавчилсан байдлаар ярьж байна. Оюу толгой дээр ч гэсэн их яарч байсан. Энэ Оюу толгойгоос өөр 34 хувь шүү дээ. Оюу толгой бол өр авч байсан үнэн. Тухайн үеийн 2008 оны парламент ядаж ичдэг байсан. Оюу толгойд бүлдэгдүүлчхээд ичдэг байсан. Одоо бол бид ядаж мэдэхгүй байж болно. Унших ёстой.

34 хувь бол роялти шилжүүлэхэд эдийн засгийн үр ашиг нь хэд юм бэ гэхэд нэг ч хариулахгүй. Энэ уран өөрөө тийм эдийн засгийн үр ашиг нь өндөр биш. Яг л картын бараагаар архи зардагтай адилхан. Энэ бол хяналт нь их чухал зүйл. Хяналт нь чухал. Архи үйлдвэрлэдэг хүн чухал биш шүү дээ. Архийг зардаг, хянадаг хүн чухал. Токаев энэ танилцуулга дээр бичсэн байна та нар хараарай. Жил болгон уран ямар үнэтэй вэ гэдгээр роялтигаа тогтоогоогүй. Жил болгон ямар хэмжээгээр 2 мянган тонныг олборлож гаргавал тэдэн хувь, 4 мянгаас дээш тэдэн хувь, 6 мянгаас хэмжээтэй уялдсан. Энэ өөрөөр хэлбэл, эрэлт хэрэгцээтэй бараа, картын бараа гэсэн үг. 6 дугаар хуудсан дээр байгаа. Казахстаны Ерөнхийлөгчөөс ядаж суръя. Төрийнхөө эрх.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Төхөөрөмжөөр санал хураана. Санал хураалт.

74.7 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 9.1.9 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

Саяын өмнөх санал хураалт дээр Батлут гишүүний, Энхтүвшин гишүүн, Батлут гишүүн, Бейсен гишүүн 3-ын саналыг дэмжсэнээр аваарай. Төхөөрөмжид, Далайн Батбаяр, Гончигдоржийн Уянгахишиг гишүүн нар дэмжсэн санал өгсөн байна. Уучлаарай Эрдэнэболд гишүүн. Жоохон тод хувцас өмсөхгүй бол харагдахгүй байна.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 9.1.9 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.1.9.энэ хуулийн 5.4, 5.5-д заасан төрийн эзэмшлийн хувь, хэмжээг өөрөөр тогтоох болон энэ хуулийн 5.5-д заасан хувилбараар орлуулах саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх”. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг,

Ганбаатар гишүүн чинь бүлгээс нэр ирсэн юм уу? Ганбаатар, Сайнхүүгийн Ганбаатар гишүүн үг хэлье.

С.Ганбаатар: Гишүүд минь их яарч байгааг чинь ойлгож байна уучлаарай. Би Улсын Их Хурлын гишүүнийхээ хувиар үг хэлэх эрхээ эдэлж байна.

Өнөөдөр энэ 34 хувийг гадаадын компанид ингэж буулгаж өгснөөрөө биднүүс шар нунтгаа буцаагаад худалдаж авах эрхгүй болж байгаа гэдгээ ойлгоорой. Бид үндсэндээ цөмийн эрчим хүч гэж ногоон хямд, бага оврын реактортай боллоо гэж мөрөөдөж.

Д.Амарбаясгалан: Ганбаатар гишүүнээ дэгээрээ яг тухайн асуудалтай.

С.Ганбаатар: Яг асуудалтай.

Д.Амарбаясгалан: Зарчмын зөрүүтэй яг холбогдож ярина шүү. Харин тийм. Би тэрийг сануулж хэлж байна.

С.Ганбаатар: Би 5.4, 5.3, 5.2-той.

5.2, 5.3-тай нарийн ярих юм бол энэ 70 оноос хойш ЗХУ, БНМАУ гэж байхад хайгуул хийж олсон ордууд шүү дээ. 51 хувь нь Монголд байх ёстой. За яах вэ тэгэхдээ 34 гэдгээрээ одоо яваад байгаа. Тэгээд би гол хэлэх гээд байгаа, энэ бүүр онцгойлж би гишүүддээ заавал хэлэх ёстой зүйл бол 34 хувийг буулгаж гаднын компанид өгснөөрөө хаа хамаагүй өсөн нэмэгдэх нь үнэ өсөх үү, буурах уу гэдгээс шалтгаалж бид өнөөдөр өөрийнхөө хараат байдлыг тэр гаднын үнэтэй холбож, Цөмийн энергийн комисс гэдэг хэдэн хүнээс цуглуулсан эзэн биегүй комисст энэ Улсын Их Хурал эрх мэдлээ өгөх гэж байгаа.

Ингэснээрээ бий болсон шар нутгаа буцаагаад худалдаж авах гэж гуйдаг байдал руу бид орно гэдгийг би бас онцгойлж хэлэх ёстой. Би өнөөдөр хэвлэл мэдээлэлд хандаагүй, ямар нэгэн ярилцлага өгөөгүй. Би чуулган дотор энийгээ ажил хэргээр ярих гэж л оролдож байгаа хүн. Тэгэхлээр хуулиас гэрээ рүү шилжиж байна. Арслан, хонь хоёр хэлэлцээрт орлоо л бол маргааш нь хонь мах болно гэж үг байдаг юм шүү дээ. Та нар Улсын Их Хурлын хууль дотор 34 хувийг үнэ төлбөргүйгээр гэж байгаа юм шүү. Оюу толгой дээр бол үнэ төлбөртэй, өрийг нь авна. Энэ үнэ төлбөргүйгээр шууд эзэмшинэ гэж шал өөр асуудал ярьж байгаа

байхгүй юу. Ийм заалтыг өөрчлөөд 0-9 хувиар өсөн нэмэгдэх рояалти гэдэг юм руу оруулж байгаа.

Өөрөөр хэлбэл, тэр Цөмийн энергийн комисс гэдэг хэдэн хүмүүст Улсын Их Хурал эрх мэдлээ өгч байгаа гэсэн үг. Энийг эргэж бодохоосоо өнгөрсөн та нар. Одоо бол шууд кнопдох байх. Би протоколд заавал оруулж энийг тусгах ёстой гэж үзэж хэлж байна. Хэзээ нэгэн цагт Монголд бага оврын реактортай болно. Одоо 450 орон цөмийн реактортай. Өнөөдөр манайх дэлхийд 11-д нь уранаараа олбор, дээгүүр. Тэгээд цөмийн энерги үйлдвэрлэхээсээ бид татгалзаж байна гэсэн үг. Энэ зүйлийг би дэмжээгүй яагаад санал вэ гэдэг дээрээ хэлж байгаа юм. Франц өнөөдөр Нигери-ээс хөөгдчихсэн, Канадад байгаа 4 орд нь дуусаж байгаа юу ч хэлэхэд бэлэн, хүлээж авахад бэлэн байгаа. Хэлэлцээр дууслаа та бидний ямар ч эрх мэдэлгүй болно гэдгийг бас энд хэлэх ёстой.

Д.Амарбаясгалан: 2 дугаар санал. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

68.4 хувиар санал дэмжигдлээ.

Батжаргал гишүүн, Зулпхар гишүүн, Энхтүвшин гишүүн, Болдын Жавхлан сайд, Галбадрах гишүүн, Батболд гишүүн, Энхтуяа гишүүн дэмжиж, Замиря гишүүн, Чинбүрэн гишүүн дэмжиж санал өгсөн байна. Протоколд тэмдэглүүлье.

Гишүүд төхөөрөмж дээрээ хуруугаа уншуулаад бүртгэлдээ орчихсон байгаа биз дээ тийм ээ? Бүгдээрээ анхааралтай байж байгаад саналаа өгье.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсгийн “хувь” гэсний өмнө “үндсэн” гэж нэмж, мөн зүйлийн 20.6, 20.7 дахь заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

20.6.энэ хуулийн 20.5-д заасан ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг тухайн ордын онцлог, цацраг идэвхт ашигт малтмалын зах зээлийн үнийн түвшнийг харгалзан Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно.”. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж, Анар, С.Ганбаатар, Г.Тэмүүлэн, Б.Батбаатар, О.Батнайрамдал, Н.Батсүмбэрэл, Ж.Баясгалан, Н.Номтойбаяр, Б.Уянга, Г.Уянгахишиг цаашид ажлын хэсэг гэх.

Пүрэвжавын Сайнзориг гишүүн дэмжсэн байр сууриар үг хэлэх юм байна. Микрофон өгье.

П.Сайнзориг: Дэмжиж байгаа. Би энэ Цөмийн энергийн хууль бас цаашдаа бас нарийн үр дагавартай хууль учраас та бас уншихдаа нөгөө штрихийг нь уншихгүй бол яг 20.6-г бид нар өөрчлөн найруулаад байгаа юм шиг болчхоод байна. 20-ийн штрих 6.

Д.Амарбаясгалан: Яг л үүгээр. Тийм байна.

П.Сайнзориг: Тийм, үүгээрээ яг протоколын хувьд зөв явахгүй бол дараа нь ингээд бас ийм байсан, байгаагүй гээд л. Ингээд л бас маргаан гараад байж магадгүй даргаа. Та энийг залруулаад хэлээд хураалгачих.

Д.Амарбаясгалан: Тэгье.

Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 20¹ дүгээр зүйлийн 20^{1.4} дэх хэсгийн “хувь” гэсний өмнө “үндсэн” гэж нэмж, мөн зүйлийн 20^{1.6}, 20^{1.7} дахь заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

20^{1.6}.Энэ хуулийн 20^{1.5}-д заасан ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг тухайн ордын онцлог, цацраг идэвхт ашигт малтмалын зах зээлийн үнийн түвшнийг харгалзан Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

84.4 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 29^{1.9} дэх хэсгийн “олборлосон” гэсний дараа “цацраг идэвхт” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

82.3 хувиар санал дэмжигдлээ.

5, Ган-Эрдэнэ тэр Энхтүвшин гишүүний төхөөрөмж ажиллахгүй байгаад байна уу? Идэрбат гишүүний төхөөрөмж? Бүртгэлд орсон юм уу хуруугаа уншуулаад?

5.Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалтын 28.2.12 дахь заалтын дугаарыг “28.2.11” гэж өөрчилж, 4 дүгээр зүйлийн “28 дугаар зүйлийн” гэсний дараа “28.2.11 дэх заалтын дугаарыг “28.2.12” гэж мөн зүйлийн” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

81.4 хувиар санал дэмжигдлээ.

6.Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалтын 34.3 дахь хэсгийн “олборлолт” гэсний дараа “баяжуулалт” гэж, “аюулгүй” гэсний дараа “булшлах” гэж тус тус нэмж, мөн хэсгийн “гүйцэтгэх” гэснийг “гүйцэтгэгч” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

С.Ганбаатар гишүүн үг өгье.

С.Ганбаатар: Эрхэм гишүүд маань энэ ураныг сүүлдээ ч ер нь аюулгүй гэж PR-дсаар байгаад энэ аюулгүй л гээд байгаа юм. Энэ чинь цацраг идэвхт ашигт малтмал гэж нэртэй юм байгаа юм шүү дээ. 1гр байсан ч гэсэн стратегийн гэсэн үг гэж бүүр хууль дээр нь зүйл, заалт байгаа.

Энэ дээр би хэлэх ёстой нэг зүйл байна. Жилд 215 мянган тонн хүхрийн хүчлийг газар ээжийн хэвлий рүү шахна гэж орж ирж байгаа шүү. 200-гийн бочкитой хэдхэн юм шахна л гэж та нар боддог байж магадгүй. Мянган бочки жилд шахна гэсэн үг. Өдөрт 15 вагон хүхрийн хүчил газар ээжийн хэвлий рүү шахаж байж энийг чинь олборлоно гэж орж ирж байгаа юм шүү дээ.

Ингэхлээр хүхрийн хүчил нийт зардлын 20 хувь байгаа. 50 сая доллар жилд. Нийтдээ 1.2 тэрбум доллар гэж тооцоолж байгаа. Өнөөдөр тэр Эрдэнэтийн ГОК-

ынхон олон жил яриад байдаг элементийн хүхэр гаргана л гэж яриад байдаг. Манайх 5 зэсийн төсөл явж байгаа. Эрх зүйн орчин дээр би оруулж байгаа санаа гэвэл Монгол орон өнөөдөр энэ хүхрийн хүчлээ өөрөө үйлдвэрлэнэ, аюулгүй байдлыг нь өөрсдөө хангана гэдэг энэ асуудал дээр яриад яриад дийлээгүй.

Өнөөдөр аюулгүй байдал сая ярилаа булшлах тухай ярьсан. Би тэрэнтэй холбогдуулж ярьж байна. Та нар энэ материалуудыг нь уншаарай энэ олон, 2 материал ирсэн байгаа та нар дээр. Яаж дээрэлхэж байна гэч дууссаны дараа хүхрийн хүчлийг нь газрын хэвлийд нь хаяна, байгаль өөрөө саармагжуулна гэж байгаа шүү дээ. Тэгээд бүр тэр дээр нэг сонин үг байгаа. Танилцуулга дээр нь байгаа. 1 метр, газрын хөрснөөс 1 метр өндөртэйгөөр трубаг тайрна, хөрсөөр булж хаяна. Энэ бол үл тоолт, энэ бол зүгээр дээрэлхэл. Энийг би хэлж байгаа нь хэлэх ёстой үед нь зөндөө хэлчихсэн учраас өнөөдөр протокол үлдээж байгаа юм.

Хоёрдугаар гол зүйл. Энэ манай байгаль орчныхон надад бүр хариуцлагатай худлаа ярьсан шүү. Би одоо араас нь бичгээр хариуцлага тооцно. Энэ аюултай хог хаягдлын үйлдвэр байгаа юу гэсэн байгаа гэсэн. Нөгөө хэдэн шприцийн үйлдвэрээ л яриад байх шиг байгаа юм. Та нар ичиж үхмээр. Энэ жилдээ 750 тонн ноцтой, аюултай хог хаягдал гарна. Энэний хог хаягдлын үйлдвэрийн талаар нэг ч эрх зүйн орчныг нь бүрдүүлээгүй. Би асуусан худлаа ярьсан. Би тэр ахуйн цацраг идэвхтэй болон бусад хог хаягдлуудыг нь яриагүй шүү дээ. Ноцтой, аюултай хог хаягдал гэдэг категори 750 тонн байгаа.

Ингээд гишүүд минь ээ цөмөөрөө Улаанбадрахын тэнд очиж амьдрах гэж байгаа юм шиг зүрх сэтгэл гаргаж, шаналж, зовж зүдэрч энэ дээр кнопоо дарна гэж би итгэж байна. Бүр сүүлдээ бүр машины паар угаахтай адилхан ярьж байна шүү дээ. Үгүй шүү дээ газар руу шууд шахна шүү дээ. Тэр газар доогуур паар гүйлгэхгүй шүү дээ, дуслын систем гүйлгэхгүй шүү дээ. Үгүй, ийм анхан шатны худлаа ярьж болохгүй. Энэ ноцтой аюултай. Байгаль орчны дүгнэлт гаргасан уу? Асуултад хариулт аваагүй л дээ. Өнөөдөр энд сууж байгаа энэ бүх хүмүүс энэ 10 жилийн дараа хариуцлага тооцох уу? Аж үйлдвэржилтийн байнгын хороогоор Улсын Их Хурлын даргад хүсэлт гаргаж энэ аюултай хог хаягдлыг боловсруулах, мөн хүхрийн хүчлийн энэ үйлдвэрийн талаар би эцэст нь хүртэл явна. Энийг протоколд оруулж байгаа юм. Тэр хөрөнгө оруулагчид энийг бас Улсын Их Хурлын чуулган дээр энийг яригдсан юм байна гэдгийг ойлгох ёстой. Ямар нэгэн үндэслэлгүй, тоо баримтгүй яриагүй шүү дээ. Бүгдийг нь уншчихаад гарцтай, гаргалгаатай ярьж байгаа ухаантай. Гишүүд маань энийг бас тунгааж бодно гэж би итгэж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Санал хураалт. 6 дугаар асуудал.

69.7 хувиар санал дэмжигдлээ.

Сайнзориг, Энхтүвшин, Номинчимэг нарын гишүүд дэмжсэн санал протоколд тэмдэглүүлнэ.

7.Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалтын 34.4.1 дэх заалтын “батлан мөрдөх” гэснийг “баталгаажуулан мөрдөх, шаардлагатай тохиолдолд гүйцэтгэлийг олон улсын хөндлөнгийн шинжээчээр хянуулах” гэж өөрчилж, 34.4.2 дахь заалтын “нэн” гэснийг, 34.8 дахь хэсгийн “15.2.1” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

77.8 хувиар санал дэмжигдлээ.

8.Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалтын 34.5 дахь хэсгийн “төрийн дансанд” гэснийг “Ирээдүйн өв сангийн Монголбанкн дахь валютын тусгай дансанд” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж.

Санал гаргасан гишүүн Пүрэвдорж үг хэлнэ.

Б.Пүрэвдорж: Энэ дээр би найруулгын, редакцын санал гаргаж байгаа. Өөрөөр хэлбэл Ирээдүйн өв сангийн гэх дээр бид нар 30 он хүртэл огт хөдөлгөж болохгүй юм байна лээ. Тийм учраас Ирээдүйн өв сангийн дансанд байрлуулж болохгүй.

Харин Монголбанкн дахь валютын тусгай дансанд байрлуулах нь зүйтэй гэж үзэж байгаа. Жишээ нь, Монголбанкны валютын тусгай дансанд жишээ нь, 302 сая долларыг жишээ нь гаднын банкнууд авчраад жишээ нь бяслагийн үйлдвэр гээд тэрэнд зориулахаар хадгалж байгаа.

Тэгэхээр манайх зүгээр шууд бүтнээр нь ингээд авчраад хадгалж байхад жил болгон 13 сая доллар орчмыг хадгалах тэр боломжийг асуудалгүй явж чадна гэж л бид үзэж байгаа. Заавал гадаадад байршуулахгүй байгаа. Мөн түүнчлэн Засгийн газрын оруулж ирж байгаа төрийн дансанд, төрийн сангийн дансанд байршуулах юм бол төсөв рүү татаж аваад хэрэглэх эрсдэл бий болж байгаа учраас энэ Монголбанкн дахь валютын тусгай дансанд хадгалж бас тодорхой хэмжээгээр жилд 4.5, 5-8 хувь, 4.8 хувийн хүү авлаа гэхэд 600 мянган доллароор бас арвижаад явах ийм боломж нь нээгдэж байгаа юм.

Дээрээс нь Монголбанкны валютын нөөц нэмэгдүүлэхэд бас үр дүнтэй, нэмэртэй олон олон давуу талууд бий болж байгаа учраас энэ заалтыг дэмжээд дээрээс нь Ирээдүйн өв сангийн гэдгийг хасаж уншиж өгнө үү.

Д.Амарбаясгалан: Чинбатын Анар гишүүн үг хэлье. Байж бай гишүүдийн байр суурийг сонсож байгаад чиглэл өгнө.

Ч.Анар: Үгүй энэ гүйцээн боловсруулах чиглэлээр буцааж өгөхийг хүсье. Яагаад гэхээр энэ 34.5 дээр Пүрэвдорж гишүүнтэй зарчмын хувьд санал нэг байгаа. Ирээдүйн өв санд тавих нь өөрөө хуулийн зөрчил үүсгэж байгаа.

Хоёрдугаарт, Монголбанкнд тусгай данс үүсгээд тавьсан ч гэсэн Засгийн газар татан төвлөрүүлэх хуулийн заалт боломжтой, эрхтэй байгаа. Тэгэхээр энэ дээр миний нэг унасан санал байгаа 34.5, 34.6 гээд.

Тэгэхээр би ер нь тэр унасан саналыгаа ч гэсэн Их Хурлын даргаас дахин боловсруулах чиглэлээр чиглэл олгохыг хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Пүрэвдорж гишүүн болон Чинбатын Анар гишүүн нарын саналаар 8 дахь саналыг гүйцээн боловсруулах чиглэл өглөө.

9.Төслийн 2 дугаар зүйлийн “5 дугаар зүйлийн 5.2, 5.3 дахь хэсэгт “Төрийн эзэмшлийн хувь хэмжээг цацраг идэвхт ашигт малтмалын ордын ашигт

малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулж болно.” гэсэн өгүүлбэр,” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

79.8 хувиар санал дэмжигдлээ.

Мандхай, Энхтүвшин, Замира, Идэрбат, Эрдэнэболд С, Далайн Батбаяр гишүүн нар дэмжсэн. Протоколд тэмдэглүүлж байна.

Энэ бас нэг зүйлийг та хэд маань зөв ойлгоорой. Одоо энэ санал хураалтын төхөөрөмж чинь шууд хувь бодож байгаа. Яг одоо жишээ нь тухайн санал хураалт хэрвээ 50 дээр, 50-н хувьдаа хүрэхгүйгээр унасан тохиолдолд санал өгч чадсангүй гэж өргөж байгаа гишүүнийг авч тэмдэглэх боломж байхгүй. Нэгэнт дэмжигдчихсэн санал учраас дэмжиж санал өгсөн гишүүдийг нэмж протоколд авч байгаа шүү. Түүнээс 49 хувьтай байж байхад нь 3 гишүүн дэмжсэн байна энэ нь ингээд 51 хувь юм гэж хэлэх боломж байдаггүй. Тэрийг бас их сайн ялгаж, салгаж ойлгох хэрэгтэй байх.

10 дугаар санал.Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 5.4 дэх хэсгийн 1 дүгээр зүйлд шилжүүлж, 5.5 болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2/5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэг:

“5.5.Энэ хуулийн 5.2, 5.3-т заасан төрийн эзэмшлийн хувь, хэмжээг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах, бүтээгдэхүүн хуваах, төрийн эзэмшлийн хувьцааны төрлийг өөрчлөх, эдгээрийг хослуулах зэрэг үр өгөөжийн дийлэнх нь Монгол Улсад ногдох хувилбарыг харгалзан Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал өөрөөр тогтоож болно.”” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж, Пүрэвжавын Сайнзориг.

Манай хоёр чинь нэг зүйл дээр санал нэгдсэн байна. Санал хураалт.

82.8 хувиар санал дэмжигдсэн байна.

Пүрэвдорж, Далайн Батбаяр, Энхтүвшин, Отгонбаяр, Идэрбат нарын гишүүд дэмжсэнээр протоколд тэмдэглүүлж байна.

11.Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтын 12.2 дахь хэсгийн “байцаагчийн” гэснийг “байцаагч (цаашид “улсын байцаагч” гэх), гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

80.8 хувиар санал дэмжигдсэн байна.

Найруулгын санал,

1.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

80.8 хувиар санал дэмжигдлээ.

Хоёр. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо дэмжээгүй санал,

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын 9.1.10 дахь заалтын “тогтоох” гэсний дараа “, цацраг идэвхт ашигт малтмал эрэх, хайх, ашиглах тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, Улсын Их Хурлын зөвшөөрснөөр эрэх, хайх, ашиглах тусгай зөвшөөрлийг олгох, бусдад шилжүүлэх” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэн. Эдийн засгийн байнгын хороо дэмжээгүй, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжээгүй санал.

Үг авах юм уу? Гараа гайгүй өргөнө шүү. Харагдахгүй яваад байна. Бадамсүрэн гишүүн, санал гаргасан гишүүн үг өгье.

С.Бадамсүрэн: Энэ хэлэлцүүлгийн явцад Цөмийн энергийн газар энэ зүгээс энэ тал дээр бас мэдээллийг нэлээн авсан. Ер нь жоохон бас мэдээлэл дутуу байсан. Гол нь миний гаргасан санал ер нь энэ цацраг идэвхт ашигт малтмал стратегийн бүтээгдэхүүн, ордынхоо хэмжээнээс үл хамаараад стратегийн бүтээгдэхүүн. Яагаад гэвэл үндэсний аюулгүй байдал, нийгэм, эдийн засагт нөлөө үзүүлэхүйц.

Дээр нь энэ газрын ховор элемент, газрын тос гээд энэ 3 зүйлийг тусгай зөвшөөрлийг олгох, бусдад эрх шилжүүлэхэд зайлшгүй Засгийн газрын хуралдаанаар ордог байх гэдэг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигтай юм байна лээ. Тэгээд энийг сүүлд мэдсэн дээ. Үүнтэй холбогдуулаад энэ зүйл дээрээ гүйцээн боловсруулах чиглэлийг өгөөч гэсэн хүсэлтийг гаргаж байгаа.

Яагаад гэвэл Ерөнхийлөгчийн зарлигаар зохицуулж байгаа зохицуулалт буюу Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж байх гэдэг зүйлийг нь энэ хууль дээр нэгэнт энэ хуульд нэмэлт, өөрчлөлт хэлэлцэж байгаа юм чинь оруулъя гэдэг л саналтай байгаа юм. Тэгээд яах вэ, би Улсын Их Хурлын зөвшөөрснөөр гэж оруулсныг Байнгын хороо дэмжээгүй учраас энийг ойлгож байна.

Харин энэ Засгийн газрын гэдгийг одоогийн зарлигийг л хуульчлаад ингээд явуулъя. Ер нь зохицуулалт нь энэ нь зөв юм үндэсний аюулгүй байдлын хувьд, нийгэм, эдийн засагт нөлөө үзүүлэхийн хувьд. Тэгээд гүйцээн боловсруулах чиглэлийг ажлын хэсэгт өгвөл энийг ажлын хэсэг дээр ярилцах боломжтой юу гэдэг санал.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн дарга, харин тийм ажлын хэсгийн дарга. Үгүй үгүй гүйцээн боловсруулах чиглэл өгөөч гэдэг хүсэлт тавьж байна л даа санал гаргасан гишүүн. Байхгүй тийм ээ? Харин тийм.

Тэгэхээр Бадамсүрэн гишүүн нэгэнт зөрчилтэй заалт юм бол татаж авах л боломж байгаа юм байна даа. Энэ чинь санал хураагаад ч нэмэргүй юм байна шүү дээ, дэмжигдээд. Энэ өөрөө Ерөнхийлөгчийн зарлигтай зөрчилдөж байгаа учраас. Харин тийм өргөн баригдаагүй, хөндөгдөөгүй. Харин тийм хөндөгдөөгүй зүйл байна.

Бадамсүрэн гишүүн энэ Тамгын газраас бас хуулийн тайлбар ирж байна.

Нэгдүгээрт, хуультай зөрчилдөж байгаа юм байна. Зөвшөөрлийн тухай хуулиар хуультайгаа зөрчилдөөд, Улсын Их Хурал зөвшөөрөл олгох гэж байгаа хэлбэр рүү орж байгаа учраас нэгдүгээрт хуулийн зөрчилтэй байна. Эс үгүй бол санал хурааж болно. Санал хураагаад унагаах юм байна, эс үгүй бол буцаан татах боломжтой юм байна. Үгүй тэгээд харин хөндөгдөөгүй зүйл дээр асуудал хөндөх боломжгүй байгаад байна шүү дээ. Энэ чинь дэг зөрчих асуудалтай гарчжаад байна. Нэг бол саналаа татаж авах боломж байна. Нэг бол санал хураалт явуулна. Санал хураалт.

74 хувиар Байнгын хорооны дэмжээгүй санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 20^{1.3} дахь хэсгийн “борлуулалтын үнэлгээний 5 хувиар” гэснийг “борлуулалтын үнэлгээний 9 хувиар” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн Төсвийн байнгын хороо дэмжсэн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо дэмжээгүй санал байна. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулна.

Ажлын хэсгийн дарга Пүрэвдорж гишүүн үг авч байна.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр энэ 27 жилийн туршид ярьсан энэ ураны төслийг урагшлуулах зорилгоор мэдээж энэ Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулж байгаа. Тэгэхээр энэ дээр тодорхой хэмжээгээр манай бас гадаад бодлого дээр бас тодорхой ахиц гарсны үндсэн дээр энэ төсөл урагшилж байгаа гэдгийг бас хэлэх нь зүйтэй.

Тэгэхээр энэ АМНАТ-ын хувьд бол энэ АМНАТ болон энэ давуу эрхийн хувьцаа мөн татвар хураамжаараа энэ 6.2-т заасан уул уурхайн газрын, ашигт малтмалын дийлэнх хувь нь монголын ард түмэнд ногдох ёстой гэдэг тэр л заалтыг бүрэн биелүүлж байгаа. Зарим хүмүүс мэдээж Казакстан улстай харьцуулдаг. Казакстан улс яг өнөөдрийн байдлаар 6 хувийн суурь АМНАТ-тай. Дээрээс нь хамгийн их борлуулалт хийлээ гэхэд 18 хувь буюу ингээд нийтдээ 24 хувийн АМНАТ байгаа. Дээрээс нь 20 хувийн аж ахуйн нэгжийн орлогын албан татвар авдаг.

Гэтэл манай энэ хуулиар 19 хувийн, дээд тал нь суурь АМНАТ 5 хувь, тусгай АМНАТ 5 хувь, мөн түүнчлэн өсөн нэмэгдэх АМНАТ нь 9 хувь ингээд 19 хувь. Дээрээс нь манай аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 6 тэрбумаас дээш байвал 25 хувь байгаа. Дээрээс нь бид нар 10 хувийн давуу эрхийн хувьцаа авч байгаа. Зөвхөн гуравхан энэ АМНАТ-аар болон аж ахуйн нэгжийн орлогын албан татвараар, хувьцаагаараа бид нар ингээд 51 хувиас дээшээ гарч байгаа юм.

Дээрээс нь бид нар нийтдээ 14, 13 татвар болон төлбөр хураамж авах ёстой. Ингэснээр энэ хангалттай хэмжээнд ашгаа авах боломж бүрдэж байгаа. Энэ дээр бол ийм хэмжээнд хүргэсэн нь бол Монгол Улсын Ерөнхийлөгчийн Макрон Ерөнхийлөгчтэй уулзсан тэр уулзалтын үр дүн, дээрээс нь энэ уулзалтын үед болсон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар ажиллаж байсан манай Амарбаясгалан дарга “Орана” компанийн захирлуудын хоорондох маш их тийм хатуу яриа, хэлцэл тэр бүх зүйл дээр энэ амжилт ирж байгаа юм шүү.

Тэгэхээр энийг Даваасүрэн гишүүн 5 хувийн суурь АМНАТ-ыг нь 4 хувиар нэмнэ гэхээр ерөөсөө л энэ төслийг зогсоогоод л гэсэн ийм л зорилго агуулж

байгаа гэж харж байгаа юм. Тэгээд энэний ард бол тийм сайн үр дүн гарахгүй. Тэгэхээр ер нь бол ийм байдлаар асуудлыг гацаадаг ийм хүмүүсийн үе бас тодорхой хэмжээгээр өнгөрсөн гэдгийг бас хэлэх нь зүйтэй.

Д.Амарбаясгалан: Пүрэвжавын Сайнзориг гишүүн дэмжиж үг хэлнэ гэнэ.

П.Сайнзориг: Би энэ дэмжээгүй саналыг дэмжье гэдэг дээр буюу Даваасүрэн сайдын гаргаж байгаа саналын эсрэг гэсэн үг, агуулгын хувьд, логикийн хувьд. Ер нь зүгээр энэ удаагийн цөмийн энергийн хуулийн нэмэлт, өөрчлөлт энэ Зөвч-Овоо гэдэг ганцхан төслийн тухай биш гэдэг зүйлийг л би залруулж хэлэх гэсэн юм.

Цаашдаа Монгол Улсад энэ уран олборлох асуудлыг том зургаар нь бид нар харах ёстой. Ганцхан энэ Зөвч-Овоог үйл ажиллагааг нь дэмжиж ашиглалтад оруулах тухай яриагүй. Цаашдаа хэд хэдэн ордын асуудал бас яригдаж байгаа. Энэний цаана гадаадын хөрөнгө оруулалтыг бид нар дэмжих гэж байгаа юм уу, үгүй юү гэдэг энэ шийдвэрийг гаргах энэ нөхцөл байдал дээр байгаа шүү гэдэг зүйлийг хэлье. Хэн ч ард түмний төлөө гэж хэлчхээд энэ ард түмэн баялагтаа эзэн байхын эсрэг ийм санал гаргаад сууж байгаа нь харамсалтай.

Тэгэхээр би өнөөдөр энэ саналыг дэмжиж саналаа өгөх гэж байгаа хүмүүс харин ч ард түмнийхээ төлөө Монгол Улсын Үндсэн хуульд заасан тэр байгалийн баялагтаа дийлэнх нь үр өгөөжийг нь хүртэх энэ ард түмний язгуур эрх ашигт нийцэж байгаа гэдэг зүйлийг би бас энд давхар хэлмээр байгаа юм. Тэгэхгүй энэ зүйлүүдийг мушгиж ерөөсөө л нэг л эх орондоо хайргүй хүмүүс л энэ асуудал дээр яриад байгаа юм шиг ийм худал мэдээлэл тарааж болохгүй.

Ер нь Казахстаны АМНАТ-ыг авах аргачлал нь өөр байхгүй юу. Бид хэд өнөөдрийн үнэ цэнээр авахад ч гэсэн 14 хувийн АМНАТ авч байгаа. Казахстаны АМНАТ-ыг авах аргачлал нь бас өөр. Өөрөөр хэлэх юм бол борлуулалт гэхээсээ илүүтэй ашгаас нь авч байна уу, үгүй юу. Энийг бас бид хэд бас мэргэжлийн байгууллагаас нь бас ялгаж салгааг нь, харьцуулалтыг нь хийж болно.

Тийм учраас Аюулгүй байдлын байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжих саналыг гишүүдийг бас дэмжиж өгөөч. Ер нь цааш цаашдаа гадаадын хөрөнгө оруулалт гэхгүй дотоодын хөрөнгө оруулалт, энэ хөрөнгө оруулагчдыг дэмжих энэ уурхайгаас тодорхой энэ салбаруудын үйл ажиллагааг дэмжиж бид бас эерэг байгаа гадаадын хөрөнгө оруулагчдыг татах сонирхолтой байгаа, хөрөнгө оруулалт Монголд орж ирэх нээлттэй байгаа шүү гэдэг энэ мессежийг бас тодорхой илэрхийлж, байр сууриа кнопоороо илэрхийлээсэй гэж гишүүдийг хүсэж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн дэмжээгүй байр сууриас үг хэлнэ.

С.Ганбаатар: Дэмжээгүй саналыг дэмжиж үг хэлье. Би нэг 20-оод жил түмний төлөө зүтгэж байна. Хүн ярих их дургүй, асуудал л ярьдаг, дуртай. Үгүй энэ чинь яасан нэг рүүгээ дайрдаг улсууд вэ. Энэ чинь 9 хувийг ард түмэндээ өгье, ард түмний эрх ашиг гэж ярихад юу нь буруу байгаа юм. Би харин хэлээд байна шүү дээ Цөмийн энергийн комиссын ажлын албанаас 2015 оны 6 сарын 26-нд АМНАТ-

ыг 9 болгоход бид бэлэн байна, дээр нь нэмээд 34 хувийн, энийг дараа нь аваарай.

Тэгэхээр ийм юм ороод ирчихсэн байгаа үед харин бид 0.5 хувиар муужруулж байна гэсэн үг. Тэгээд ярихлаараа зэрэг 19 он хүртэл бид нэмж байгаа. Тэгээд 9-ийг нэмэхлээр буруудна гэж ярьж байна. Миний гол хэлэх гээд байгаа санаа гэвэл бид асуудлаа ярьж суръя. Ямар нэгэн хүн рүү битгий ор, юу ч ярьж болно. Гишүүд сонгогчдынхоо төлөө ярих эрхтэй.

Тэгэхээр өнөөдөр энэ асуудлуудаа судалж, АРЕВА өөрөө тэртээ тэргүй 0.5 хувиар буулгаад өгчихсөн юм дээр, за гэхихсэн юман дээр, хэлж байгаа юман дээр бас битгий өмнөөс нь их санаа зов. Яарч байж болно. Ямар хар сүүдэр та нарын минь дайрчхав.

Д.Амарбаясгалан: Дэмжсэн байр суурь. Яах вэ, намын бүлгийг төлөөлж 2, 2 гишүүн үг хэлэх боломжтой юм. Тэгэхээр Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн үг хэлье. Батсүмбэрэл гишүүний микрофоныг өгье.

Н.Батсүмбэрэл: Энэ сая бас буруу л ярьж байна олон жил суусан ах маань. Энэ чинь Оранагийн хууль биш, Цөмийн эрчим хүчний, Цөмийн энергийн тухай хууль. Энэ Их Хуралд олон жил суучхаад өөрсдийгөө бүгдийг мэддэг царай гаргадаг ах нар больцгоо. Эх оронч дүр гаргаж эх орны эсрэг юм хийдгээ больцгоо. Ганбаа ах аа одоо наад маскаа тайл, одоо маскаа тайл.

Тийм учраас өөрөөр хэлбэл, энэ ажлын хэсгийн гишүүний хувьд ажлын хэсэг гаргасан саналыг дэмжиж байгаа юм. Худлаа ингэж попорч, худлаа жүжиг тавьж, эх орончийн царай гаргадаг байдалтай хүмүүсээ бид бодитой харах хэрэгтэй. Одоо нэг нэгнийгээ хамгаалж байна. Энэ байдлыг олон жил бүгдээрээ энэ парламентад хийж хэвшицгээчихсэн юм байна лээ. Тэр санаачилсан нөхөр бол өөрийнхөө удирддаг төсвийн хороон дээр хүмүүсийнхээ ирцийг харж байгаад хийчихсэн юм шиг байгаа.

Харин Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо бол бүтэн ирцтэйгээр бүгдээрээ энэ төслийг явуулъя гэж дэмжсэн шүү. Ажлын хэсгийн дарга Пүрэвдорж дарга энэ дээр маш хатуу байр суурьтай байгаа шүү. Ийм учраас Их Хурлын гишүүдийг дэмжээгүй саналыг дэмжиж санал өгөхийг уриалж байна.

Д.Амарбаясгалан: Ер нь бол яах вэ, нэг зүйлийг бас бүгд анхааралтай харах хэрэгтэй. Энэ парламент дээр мэдээж байр суурь зөрүүтэй байх бүх нөхцөл боломж нээлттэй.

Гэхдээ энэ бол цаашдаа улс орны хувь заяатай холбоотой чухал асуудал. Ард түмэндээ зөв ойлголт, мэдээллийг өгөх ёстой гэдэг тэр байр суурь дээрээсээ маш их хатуу хандах ёстой шүү. Сая Ганбаатар гишүүн Цөмийн энергийн ажлын албанаас авсан мэдээлэл гэж 2, 3 зүйлийг бас жишээ авч хэлж байна. Бусад байр суурь илэрхийлж байгаа гишүүд бас зарим талаар бас мэдээлэл илүү учраас бас өөрсдийн байр суурийг тодорхой илэрхийлж байгаа зүйлүүд харагдаж байна.

Тэгэхээр энэ ажлын албаны хүмүүс, мэргэжлийн байгууллагын хүмүүс Улсын Их Хуралд, Улсын Их Хурлын гишүүдэд мэдээлэл өгөхдөө хоёрдмол ойлголтгүйгээр, бодитой, баталгаатай мэдээллийг өгч ажиллах ёстой. Түүнээс энэ

зүгээр улс төржөөд явчихдаг сэдэв бас байж болохгүй. Монгол Улс гаднын хөрөнгө оруулалтыг татах, эдийн засгийнхаа нөхцөл боломжийг улам бүүр сайжруулах, 1 хүнд оногдох ДНБ-ийг богино хугацаанд 10 мянган долларт хүргэх, тэрний төлөө хамтарсан Засгийн газар байгуулагдаж томоохон зориг гаргаж, томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх алхмыг хийж байгаа энэ цаг үеийг бид хэрхэвч алдаж болохгүй юм байгаа юм.

Харин энэ дээр бүгд ижил түвшний мэдээлэлтэй байх нөхцөлөөр ажлын албаныхан маш сайн хангаж байна шүү. Энэ АМНАТ-тай холбоотой асуудал хөндөгдөж 5 хувь, 9 хувь гэж ярьж байгаа боловч яг эцсийн дүндээ энэ дараа дараачийн гэрээ, төсөл орж ирэхээр бодитоор хэлэлцээр яаж явагдаж байгаа, Монгол Улсад ямархуу үр өгөөж нь ирэх юм, нийт төслийн хэрэгжих хугацаа нь хэд байх юм, төсөл хэрэгжих хугацаа нь Монгол Улсад, Монгол Улсын иргэнд ямар үр өгөөж ирэх юм бэ гэдэг зүйлүүд бол илүү тодорхой яригдах боломжтой гэж байгаа юм.

Өнөөдөр зөвхөн Цөмийн энергийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт яригдаж байгаа учраас энэ гэрээний төслийн талаар дэлгэрэнгүй ярих боломжууд хумигдмал байгаа. Энд хуулийн төсөл маань өөрөө зөвхөн нэг гэрээний асуудал болж явчих гээд байгаа учраас зарим зүйлийг тодорхой ярих боломжууд бол хумигдмал байгаа. Зөвхөн хэлэлцэж байгаа асуудал нь хуулийн төсөл учраас энэ дээр хязгаарлагдаж байгаа гэдгийг гишүүд тал талаасаа ойлгох хэрэгтэй. Ганбаатар гишүүндээ ч гэсэн бас энэ дээр зориуд тайлбарлаж хэлэхэд энэ хуулийн нэмэлт, өөрчлөлт хийгдсэний дараа тэр дараа дараачийн тодорхой аж ахуйн нэгжүүдтэй, тодорхой улс гүрэнтэй хамтарсан гэрээ байгуулах эсэх асуудал нь өөрөө Улсын Их Хурлаар орж ирж, өргөн хүрээгээр хэлэлцүүлэгдэж шийдэгдэнэ гэдгийг маш сайн ойлгож та бүхэн маань хандаарай.

Түүнээс өнөөдөр бол хуулийн төсөл явж байгаа шүү гэдгийг хэлье ээ.

Ингээд 2 дахь Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

80.4 хувиар санал дэмжигдсэн байна.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалтын 34.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“34.5.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхай, үйлдвэрийн хаалт, нөхөн сэргээлт, хаалтын дараах засвар арчилгаанд зарцуулах мөнгөн хөрөнгийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нэр хүнд бүхий банк, санхүүгийн байгууллагын санхүүгийн хэрэгсэлд байршуулна.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Анар.

Анар гишүүнд үг өгье.

Ч.Анар: Нэгдүгээрт, энэ найруулгын санал биш, зарчмын санал.

Хоёрдугаарт, түрүүн дахин боловсруулах чиглэл өгсөнтэй холбогдолтойгоор 34.5 маань 34.6 гэчихсэн заалттайгаа холбоотой байгаа. Тэгэхээр энийг би

протоколд тэмдэглүүлж, үлдээхийг хүсэж байна. 34.5 дугаар заалт, 34.6 дугаар заалттай хамт дахин боловсруулах чиглэл өгнө үү.

Д.Амарбаясгалан: Байз нэг ийм зүйлийг бид ойлгохгүй бол болохгүй юм байна. Энэ хар аа мэргэжлийн Байнгын хорооны дэмжээгүй саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөх боломжгүй юм байна.

Яагаад гэхээр энэ чинь өөрөө санал хураалтаар асуудал шийдэгдэж байгаа шүү дээ. Эндээс гүйцээн боловсруулах чиглэл өгчихвөл энэ саналыг нь шууд босгоод өгчхөж байна шүү дээ. Улсын Их Хурлын гишүүдийн санал өгөх эрхэд шууд нөлөөлж байгаа дэгийн зөрчил үүсэх учраас гүйцээн боловсруулах чиглэл өгөх ямар ч боломжгүй. Байнгын хорооны дэмжээгүй саналыг гүйцээн боловсруулъя гэдэг гэдэг ойлголт байх боломжгүй байна гэсэн үг.

Тэгэхээр татаад авч болно гэсэн үг. Санал гаргасан гишүүн Чинбатын Анар гаргасан саналаа татаж авч байна.

4.Төслийн 3 дугаар зүйлийн 30.1.1.тогтворжуулах татварын орчныг тогтоох гэсэн 3 дахь заалтыг хасах.

Чинбатын Анар гишүүнд микрофон өгье. Саналаа татах талаар үг авъя гэсэн.

Ч.Анар: Санал татаж авч байгаа биш. Энэ угаасаа түрүүн гүйцээн боловсруулахаар Пүрэвдорж гишүүний саналыг авчихсан буцаагаад. Тэгэхээр тэн дээр 34.6 дугаар заалт нь хамт орох ёстой гэдгийг л протоколд тэмдэглүүлж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Тийм, Пүрэвдорж гишүүний микрофоныг өгье.

Б.Пүрэвдорж: Энэ хэдийгээр дэмжээгүй ч гэсэн би Анар гишүүнд нэг зүйлийг зөвлөмөөр байна. Өөрөөр хэлбэл, миний гаргасан хэд дэх санал. Тийм, 8 дахь санал дэмжигдсэн санал дээр та яг Байнгын хороон дээр гараад, ороод бас тодорхой санал гаргаад тэрийгээ дэмжүүлж болно.

Тийм учраас та энэ дэмжээгүй саналыг Байнгын хороо руу буцаах боломжгүй учраас 3 дугаар саналаа та буцаагаад татаад авчих. Тэгээд миний гүйцээн боловсруулах санал дээр та хамтдаа ярилцаж байгаад асуудлаа оруулж болно. Дэмжигдвэл, дэмжигдвэл. Байнгын хор.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Чинбатын Анар гишүүнд микрофон өгье.

Ч.Анар: 3 дугаар саналыг татаж байна.

Д.Амарбаясгалан: 3 дугаар санал татагдлаа.

4.Төслийн 3 дугаар зүйлийн “30.1.1.тогтворжуулах татварын орчныг тогтоох;” гэсэн 3 дахь заалтыг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр.

Б.Энхбаяр гишүүнд микрофон өгье.

Б.Энхбаяр: Өчигдрийн Улсын Их Хурлын нэгдсэн чуулган дээр энэ Татварын ерөнхий хуульд оруулах гэж байгаа тогтворжуулах татварын орчныг тогтоох гэдэг энэ хуулийн өөрчлөлт нь одоо Лондоны Арбитрт явж байгаа “Оюу толгой” компанийн татварын маргаанд айлын талд давуу байдал олгохгүй гэдгийг Засгийн газрын гишүүн Сангийн сайд Жавхлан, Туваан, Алтангэрэл нар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд батлан дааж, протоколд үг хэлсэн учраас энэ саналаа татаж авч байна.

Д.Амарбаясгалан: 4 дэх санал татагдлаа.

5.Төслийн 4 дүгээр зүйлийн “20” гэж гэсний дараа “, мөн хэсгийн “байгуулж болох бөгөөд түүнд” гэснийг “гэрээний биелэлтийг 5 жил тутам дүгнэх, шаардлагатай тохиолдолд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд гэрээнд” гэж” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал, Б.Уянга.

Отгоншарын Батнайрамдал гишүүнд микрофон өгье. Санал гаргасан гишүүн.

О.Батнайрамдал: Энэ заалтын агуулга нь ерөөсөө л урт хугацааны гэрээ бид нар байгуулахдаа буцаад дүгнэдэг, хоёр талаасаа дүгнэдэг ийм зарчмаа л оруулъя гэсэн юм. Тэгээд яах вэ, энийг Аюулгүй байдал байнгын хороон дээр ажлын хэсгээс хөрөнгө оруулалтын гэрээн дээрээ тусгана гэж хэлсэн байгаа. Протоколд үлдсэн.

Тийм учраас бас яах вэ, энэ гэрээ нь нөгөө хууль дээрээ тусахгүй хэрвээ гэрээн дээрээ л тусчих юм бол нь болчих заалт байгаа юм. Тэгэхээр ийм тийм учраас Уянга гишүүн бид хоёр энэ саналаа татаж авч байна.

Д.Амарбаясгалан: Санал гаргасан гишүүн саналаа татлаа.

6.Төслийн 4 дүгээр зүйлийн “20” гэснийг “10-20” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Пүрэвийн Батчимэг.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

70.6 хувиар санал дэмжээгүй санал дэмжигдлээ.

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Нэг.Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо дэмжээгүй санал.

1.Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр.

Б.Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Энэ бас сая яг Хөрөнгө оруулалтын тухай хуульд тогтворжуулах татварын орчин гэдэг заалтыг оруулж ирсэн байгаа. Мөн түрүүн хэлсэнчлэн Лондоны арбитрын арбитр дээр явж байгаа Оюу толгойн татварын маргаанд айлын тал давуу байдал энэ хуулийн өөрчлөлтөд оруулахгүй гэдгийг Засгийн газрын 3 сайд Улсын Их Хурлын чуулган дээр батлан дааж үг хэлсэн үндэслэлээр энэ саналаа буцаан татаж байна.

Д.Амарбаясгалан: Санал татагдлаа.

2.Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо дэмжээгүй санал.

1.Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр.

Б.Энхбаяр гишүүний микрофон өгье.

Б.Энхбаяр: Ер нь энэ татварын хуульд өөрчлөлт оруулах асуудал маш нухацтай хандаж байх ёстой. Татварын хууль ийм, Иргэний хууль, Татварын хууль, Эрүүгийн хууль, Төсвийн тогтвортой байдлын хууль гэдэг энэ тухайн салбаруудынхаа дэд Үндсэн хууль маягтай үйлчилдэг хуулиудын асуудлын өөрчлөлтийг ер нь ямар өөр хууль дагалдуулж өргөн барьж байгаагүй, барьж баймааргүй байна. Тийм.

Яагаад гэхээр энэ өөрчлөлтүүд нь бусад хууль, харилцаанд үйлчлэхээс гадна Монгол Улсын байгуулсан хөрөнгө оруулалтын томоохон дүнтэй гэрээнүүдэд яаж үйлчлэх вэ гэдэг дээр маш их судалгаа шаардагддаг.

Тийм учраас би энэ Улсын Их Хурлын чуулган, Байнгын хороо дээр ажлын хэсэгт удаа дараа энэ асуулт асуугаад байсан тэр. Энэ Оюу толгойн гэрээнд яаж нөлөөлөх юм бэ? Одоо бид нар чинь 14 мега төсөл яриад байгаа байхгүй юу. Энэ төслүүд чинь Их Хурлаар орж ирнэ гээд байгаад байна шүү дээ. Тэгэхээр энэ хөрөнгө оруулалтын гэрээнүүдэд ялгавартай тийм нөхцөлүүдийг олгож болохгүй байдаг.

Тийм учраас энэний цаана ямар мөнгө яваад байгаа, ямар давуу байдал хэн нэгэн юм уу, аль улсад юм уу олгох гээд байгаа вэ гэдэг асуудал их нухацтай хандах ёстой асуудал байдаг. Дандаа тооцоо, судалгаатай. Тийм учраас Засгийн газар ийм татварын хуулийн өөрчлөлтүүд дээр тооцоо, судалгаагүй ийм хууль дагалдуулж том өөрчлөлт оруулж ирдгээ болих хэрэгтэй байгаа юм.

Тийм учраас асуулт асуугаад байсан. Энэ Лондоны арбитрын маргаанд нөлөөлөх юм уу, нөлөөлөхгүй юм уу гэдгийг чинь тэгээд асуугаад байсан юм. Манай ажлын хэсгийн ахлагч бол их туршлагатай хүн учраас огт хариулсангүй л дээ. Хариулахгүй байсаар байгаад одоо дуусаж байгаа Пүрэвдорж. Пүрэвдорж дарга энд ерөөсөө за ч гээгүй, үгүй ч гээгүй. Ерөөсөө ингээд л нэг бодлын ширэн нүүрлэсэн гэж хэлэхэд хаашаа юм. Нөгөө бодлын одоо их туршлагатай учраас Жавхлан сайд руу нэг чихээд л, намынхаа Туваан сайд руу бултуулаад л ингээд л дуусгаж байгаа байхгүй юу.

Тийм учраас би энэ протоколд бас дахиж хэлээд, энэ Татварын ерөнхий хуульд орж байгаа нэмэлт, өөрчлөлт бол Лондоны арбитр дээр явж байгаа хэдэн их наядаар хэмжигдэх маргаан шүү. Энэ хэдэн их наяд. Татварын маргаанд энэ хууль айлын талд давуу байдал үзүүлэхгүй гэж Засгийн газрын 3 сайд Улсын Их Хурлын чуулган дээр протоколд хэлсэн учраас тэр үндэслэлээр энэ саналаа татаж авч байна.

Д.Амарбаясгалан: Санал татагдлаа.

3.Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжсэн санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “Хуульд” гэсний өмнө “Цөмийн энергийн тухай” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшин.

Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн.

Аан за, Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Энхтүвшин гишүүнээ таны бас олон олон санал гаргасан. Тэгээд энэ дээрээ заримыг нь аваад, найруулгын шинжтэй өөрчлөөд бас явсан. Тэгээд яг энэ, яг таны гаргасан энэ “Хуульд” гэсний өмнө “Цөмийн энергийн тухай” хууль гэж тодорхойлж өгөх. Уг нь бол гав ганцхан цөмийн энергийн хуульд энэ заалт орж байгаа байхгүй юу даа.

Тэгэхээр өөр бусад хэрэглээн дээр хэрэглэхэд тэр Цөмийн энергийн хуулиа гаргаж ирээд л татаад авчхаж болох юм. Тэгэхээр та заавал Цөмийн энергийн хууль гэж оруул гэсэн учраас энэ дээр чинь санал хураалт явуулаад дэмжсэн.

Гэтэл өчигдөр тэгээд энэ Их Хурал хог новш, тэгээд хүнд ийм энэ Их Хурлын гишүүд л муу муухай гэж хэлж байгаа чинь ямар уваагүй юм бэ. Ингэж болохгүй шүү дээ. Таны өөрийнхөө саналыг дэмжүүлчхээд араас нь миний саналыг дэмжсэн Их Хурал, тэр Байнгын хороо, ажлын хэсэг муухай гэдэг чинь бас болохгүй байхгүй юу даа. Би танд зүгээр л энд хэлье гэж бодсон юм.

Д.Амарбаясгалан: Дэмжиж үг хэлнэ Б.Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Ажлын хэсгийн ахлагч тэгж бас үймүүлэхгүй шүү. Яг тэр дээрээ тулбал байна шүү дээ Засгийн газраас энэ орж ирсэн төсөл өөрөө асуудалтай шүү харин тэгж яривал.

Яахаараа Компанийн хуулийн ийм суурь харилцааг Цөмийн энергийн хууль дагуулж өөрчилж байгаа юм? Энэ бүх компаниудад хамаатай тэгвэл. Бүх энгийн хувьцаануудыг давуу эрхийн хувьцаа болгож олох боломжийг зүгээр нэг хуулийн ард ямар ч тооцоо, судалгаагүй, ямар ч үндэслэлгүй оруулж ирсэн хэрэв тэгвэл. Энэ Оюу толгойн гэрээнд ч хамаатай шүү дээ.

Тийм учраас энэ Оюу толгойд хамаарахгүй ээ, бусад Монгол Улсын 15 стратегийн ордод хамаарахгүй гэдгийг хашиж Цөмийн энергийн хуульд л энэ үйлчилнэ шүү гэдгийг хашиж өгсөн юм Аюулгүй байдал байнгын хороо.

Тийм учраас энэ дээр бол Энхтүвшин гишүүний гаргасан санал бол харин зөв. Хэрэв буруутгах гэж байгаа бол энэ төслийг бүр буцаах ёстой. Хэрэв, тийм зарчим ярих гэж байгаа. Тийм учраас би энэ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжиж өгөөч гэж гишүүдээсээ хүсэх гэж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо.

Тэмүүжин гишүүн үг хэлье.

Х.Тэмүүжин: Үнэхээр Энхбаяр гишүүний хэлж байгаа зүйл бол үнэн байгаа. Энэ хуулийн этгээд, тэр дундаа Компанийн хуультай холбоотой асуудал чинь Хууль зүйн байнгын хорооны үндсэн асуудал байхгүй юу. Гэтэл Хууль зүйн байнгын хороо огт хуралдаагүй, энэ тухай огт мэдээгүй.

Эдийн засгийн байнгын хороо, Аюулгүй байдлын байнгын хороодоор орж ирээд анх удаа Компанийн хуулийн суурь зарчим, энгийн хувьцааг өөрчлөх тухай тэр хуулиар чинь энэ чинь өөрөө хориотой байхгүй юу.

Яагаад хорьж өгч байгаа вэ гэхээр хэрвээ энгийн хувьцааны ард байгаа санхүүгийн хариуцлага гэх мэтчилэн олон ойлголтыг зүгээр хувьцааных нь төрлийг өөрчлөөд шийдчихдэг бол компани чинь тэр чигээрээ залилангийн гэмт хэрэг болно шүү дээ. Компани байгуулж, бизнес эрхлэх чинь зүгээр л хэн нэгэнд сайн дураараа эд хөрөнгөө дээрэмдүүлэх, тонуулах үйл ажиллагаа болж хувирна шүү дээ. Ийм ноцтой асуудлыг Хууль зүйн байнгын хороо мэдэхгүй, Хууль зүйн яам нь яасан юм мэдэхгүй, өөр Байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд Засгийн газар өөр хуулийг дагуулаад, хавчуулаад оруулаад ирж байгаа байхгүй юу. Энэ чинь Засгийн газрын хариуцлагагүй байдлын хамгийн том ноцтой асуудал шүү. Үнэнийг хэлбэл, цаашаа явбал.

Тийм учраас бүүр зорилготойгоор зөвхөн Цөмийн энергийн хууль гэж энэ дээр тодотгож өгье. Тэгэхгүй бол энэ Компанийн хуулийн чинь тулгуур зарчим эвдэгдээд, Компанийн хууль Монголд байх утга алга болох гэж байгаа байхгүй юу.

Тийм учраас ер нь цаашдаа даргын зөвлөл дээр ч гэсэн Байнгын хороод ярилцахдаа өөрийнх нь салбарын үндсэн асуудал орж ирж байхад хажуугаар нь дуугүй өнгөрч болохгүй. Мэргэжлийн Байнгын хороо энэ дээр ямар нэгэн байдлаар

дүгнэлт хийх ёстой, салбарынхаа хувьд ярилцах ёстой гэдэг ийм хуульд, Улсын Их Хурлын хэлэлцүүлгийн эрүүл тогтолцоо руу орохгүй бол суган доогуур хууль гараад явж байгаа тохиолдлууд гараад байна шүү.

Д.Амарбаясгалан: Дамдины Цогтбаатар гишүүн, микрофон өгье.

Д.Цогтбаатар: Гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Энэ аягүй чухал асуудал гарч ирж байгаа юм шүү. Их Хурлын даргын томилсон ажлын хэсэг Хууль тогтоомжийн тухай хуулийн ажлын хэсгийг би даргалж байгаа. Энэний нэг гол зорилго нь яг ингэж хууль дагуулж орж ирж хууль өөрчилдөг энэ юмыг зохицуулахгүй бол болохгүй байна гээд энэ Хууль тогтоомжийн хуульд өөрчлөлт оруулах гээд судалгаа хийгдээд яг явж байгаа. Удахгүй бид нар өргөн барих гэж байгаа.

Тэгээд энэ дээр зүйлийг хэдүүлээ анхаармаар байна. Яг өнөөдрийн явж байгаа процесс бол гэрээнд зориулж хууль өөрчилж байгаа юм. Энийгээ бид нар, тийм учраас энд хүмүүс андуураад одоо явж байгаа юмыг эрх зүйн томъёогоор нь нэрлэвэл бид нар дэгээрээ хууль хэлэлцэж байгаа боловч дефакто гэрээ хэлэлцээд суугаад байгаа байхгүй юу. Энэ чинь өөрөө эргээд маш ноцтой зүйлүүдийг гаргаж ирээд байна.

Тэгэхлээр ер нь яг энэ гэрээн дээрээ, биш ээ юу, хууль дээрээ төвлөрч, яагаад гэвэл энэ хууль дараа нь маш олон гэрээг зохицуулах болохоос биш гэрээ хуулийг зохицуулдаг юм биш шүү.

Тэгээд энийгээ яг хуулиа бодож бид нар хэлэлцүүлгээ явуулахгүй бол дандаа яг тэр цаана явж байгаа гэрээтэй холбож асуудлуудаа яриад байна. Тэр гэрээ чинь хуульд зохицуулагдах ёстой. Түүнээс гэрээнд тааруулж хуулиа хийх гээд байгаа юм шиг ийм нөхцөл байдал үүсээд байна шүү.

Д.Амарбаясгалан: Мөнхсоёл гишүүн.

Б.Мөнхсоёл: Өглөөний мэнд.

Тэгэхээр би бас энэ Цогтбаатар гишүүний хэлсэнтэй санал, бас бусад Энхтүвшин гишүүний санал гаргасан Эдийн засгийн байнгын хороогоор дэмжигдсэн, Аюулгүй байдлын хороогоор бас дэмжигдсэн. Тэгээд энэ хурлын үйл явцыг ажиглахад энэ чинь яг Цогтбаатар гишүүний хэлж байгаатай адилхан хуулийн хүрээнд бусад үйл явцууд зохицогдох ёстой шүү дээ.

Гэтэл тэрийгээ бид нар үл анзаараад алдаа хийчих гээд байна гээд энэ олон асуудлыг няхуур хараад санал гаргасан хүмүүсийнхээ саналыг хувь улс төрчийн тоглолт болгоод унагаагаад байх нь өөрөө буруу юм. Энийг бид нар гишүүд ард байгаа 3 сая, 3.5 сая хүнийг төлөөлж байгаагийнхаа хувьд энэ танхимаар төсөөлөлгүйгээр асуудалд ханддаг, нухацтай ханддаг байцгааж суръя. Зөвхөн хувь хүний хоорондын, хувь улс төрчдийн хоорондын харилцаад явчихвал бас эргээд.

Д.Амарбаясгалан: Хэлэлцэж байгаа асуудал дээрээ ярина.

Б.Мөнхсоёл: Тийм асуудал гарах нь байгаа. Тэгэхээр Эдийн засгийн байнгын хороогоор дэмжчихсэн саналыг дэмжих ийм зорилготойгоор үгээ хэлж байна.

Д.Амарбаясгалан: Одоо болно байх аа. Энэ чинь Эдийн засгийн байнгын хороо дэмжчихсэн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо дэмжчихсэн. Одоо дэмжсэн саналыг дэмжье гээд санал хураах гэсэн чинь ахиад асуудал болгох юм. Энэ чинь ер нь тэгээд санал дэмжиж болохгүй, дэмжихгүй байж болохгүй юм руу явчих гээд бүгд дээр нь үг авдаг хэлбэр гарах гээд байна шүү.

Ер нь яах вэ, гишүүд маань бас зөв л ярьж байна л даа. Одоо бид яг юуг хэлэлцэж байгаа вэ гэдэг дээр илүү төвлөрч ярьж сурцгаахгүй бол гэрээнд зориулсан гэрээ яриад байдаг, тэгсэн мөртөө хуулийн өөрчлөлт хийгээд байгаа юм шиг хэлбэр харагдаад, олон нийт ч бас эндээс зөв, бодитой мэдээллийг авч чадахгүй байгаа ийм тал бас байгаа. Ингээд хоёр Байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

81.7 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүллээ.

Дараачийн санал хураалт байгаа шүү гишүүд байж байгаарай. Одоо санал хураалт байгаа. Энхтүвшин гишүүнийг дэмжсэнээр протоколд авъя. Дараачийн асуудал.

11.09 цаг

“Монгол Улсын Их Хурлын 2024-28 оны стратеги төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан.

Одоо Байнгын хорооны саналаар “Монгол Улсын Их Хурлын 2024-28 оны стратеги төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

59.6 хувиар тогтоол батлагдлаа. Тогтоолын төсөл батлагдлаа Улсын Их Хурлын.

Номин гишүүн, С.Эрдэнэбат, Хэрлэн гишүүн, манай Жангабыл гишүүн, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн, Замира гишүүн, Сайнбуянгийн Амарсайхан, Ганхүлэг гишүүн, Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн, Батболд гишүүн, Батчимэг гишүүн, Батбаяр гишүүн, Ц.Мөнхбат гишүүн, С.Эрдэнэболд гишүүн нар дэмжиж санал өгсөн байна. Протоколд тэмдэглэе.

Тогтоолын төсөл батлагдлаа. Улсын Их Хурлын гишүүдэд талархал дэвшүүлье. Дараачийн асуудалд орно.

11.10 цаг

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3-д Улсын Их Хурлын энэ хуулийн 46.1.2-т заасан хууль, тогтоолын эцсийн найруулгатай танилцаж, ёсчлохыг зөвшөөрөх гэж заасны дагуу хууль тогтоолын эцсийн найруулгыг Байнгын хороод бэлтгэж, Улсын Их Хуралд танилцуулахад бэлэн болсон байна.

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Дагалдан гарсан,

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

3.Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

4.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

5.Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

6.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

7.“Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

8. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Уянгахишиг гишүүн байна. Микрофон өгье.

Г.Уянгахишиг: Энэ тогтоолыг 25 оны 1 сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гээд явчихсан байна шүү дээ тээ? Тэн дээр болж байгаа юм уу? Энэ чинь өөрөө уг нь Засгийн газарт чиглэл өгчихөөр өнөөдрөөс эхлээд л уг нь дагаж мөрдмөөр. Тэгээд ингээд бүгд яг энэ дагаж мөрдөх дээрээ Тамгын газар бас анзаарч байхгүй бол би өмнө нь хэлж байсан шүү дээ. Хууль бол тухайн 25 оны 1 сарын 1-нээсээ эхэлж болно.

Гэтэл тогтоолууд дээр ихэнхдээ батлагдангуутаа хийгдэх ажлууд байгаад байгаа учраас энэ дагаж мөрдөх хугацаагаа аягүй сайн анзаарч байгаач.

Д.Амарбаясгалан: Баасандорж дарга.

Б.Баасандорж: Уянгахишиг гишүүний асуултад хариулъя.

Энэ хоёр тогтоол байгаа шүү дээ гишүүд ээ. Нэг нь “Засгийн газарт чиглэл өгөх тухай” нэг тогтоол байгаа. Тэр бол яг төсөвтэй холбоотой.

Яг гишүүдээс гарсан саналтай холбоотойгоор Төсвийн байнгын хорооноос оруулсан 2025 оны улсын төсвийн хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай тогтоол гээд тусдаа байгаа. Тэр дээр яг тодотголыг оруулж ирэх холбоотой асуудлуудыг зохицуулсан байгаа. Ийм хоёр тогтоол байгаа шүү Уянгахишиг гишүүнээ.

Д.Амарбаясгалан: Эцсийн найруулгыг.

Уянгахишиг гишүүн.

Г.Уянгахишиг: Баасандорж дарга тэрийг ойлгож байгаа. Одоо яг энэ Засгийн газарт чиглэл өгөх тухай гээд энэ төсөв, санхүү, татварын орчныг боловсронгуй болгож, олон улсын стандартад нийцүүлэх төсвийн хөрөнгөөр гэдэг тэр дээр санал явж байгаа шүү дээ дарааллаараа. Тэр орж ирж байгаа байхгүй юу.

Яагаад гэхээр энэ чинь нөгөө дугаар байхгүй учраас би яаж ялгаж хэлэх нь ойлгомжгүй байна л даа.

Д.Амарбаясгалан: 8 дээр явж байгаа шүү дээ.

Г.Уянгахишиг: Тийм, 8 дээр. Яг одоо “Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай”-гийн дараагийнх.

Д.Амарбаясгалан: Тийм.

Г.Уянгахишиг: Тийм, тэгэхээр яг тэр дараагийнх чинь шүү дээ Баасандорж даргаа.

Д.Амарбаясгалан: Уянгахишиг гишүүнээ сая Баасандорж дарга хэллээ шүү дээ хоёр тогтоол байгаа. Нэг нь 2025 оны төсвийг даагаад Засгийн газарт чиглэл өгөх нэг тогтоол.

Г.Уянгахишиг: Тийм.

Д.Амарбаясгалан: Хоёр дахь нь бид өнгөрсөн гурав, дөрөвдүгээр хэлэлцүүлэг дээр санаачилж, Төсвийн байнгын хорооноос санаачилж гаргаж ирсэн Арга хэмжээ авч, аль юу билээ? Тийм, арга хэмжээ авч хэрэгжүүлэх тэр тогтоол байгаа шүү дээ. Төсвийн тодотгол хийхтэй холбоотой. Тэр чинь тусдаа. Та тэрэнтэй андуураад байх шиг байна.

Ингээд эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Саяын Уянгахишиг гишүүний хэлсэн саналыг бас тусгаад явъя.

9.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчид”-д нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Энэ төсвийн хүрээг уншилгүй орхисон байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-27 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Холбогдуулан боловсруулсан,

“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

1.Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

“Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

“Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууслаа.

Хуралдаан өндөрсдөгийг мэдэгдье.

13 цагаас даргын дэргэдэх зөвлөлийн хуралтай.

11.17 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР

